

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/357/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: <a href="mailto:naranchimegts@audit.gov.mn">naranchimegts@audit.gov.mn</a> Аудитын менежер: В.Эрдэнэцогт Утас: 261885 Цахим хаяг: <a href="mailto:erdenetsogtv@audit.gov.mn">erdenetsogtv@audit.gov.mn</a> Ахлах аудитор: М.Пагамдулам Утас: 261628 Цахим хаяг: <a href="mailto:pagamdulamm@audit.gov.mn">pagamdulamm@audit.gov.mn</a> Аудитор Ж.Бямбацогт Утас: 261628 Цахим хаяг: <a href="mailto:byambatsogtj@audit.gov.mn">byambatsogtj@audit.gov.mn</a>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	16
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	21
4.1 Ерөнхий зүйл .....	21
4.2 Материаллаг байдал.....	21
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	21
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	21
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	22
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	22
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	23
5.1 Төлбөрийн акт.....	23
5.2 Албан шаардлага .....	24
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	26

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНТУ	Бүгд Найрамдах Турк Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ТББ	Төрийн бус байгууллага
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН  
ТӨВИЙН ЗАХИРАЛ М.ОДГЭРЭЛ  
ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/308  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу, хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Тухайлбал:

- Жилийн эцэст 25,754.0 мянган төгрөгийн авлага, урьдчилж гарсан зардлыг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй;
- Бараа ажил, үйлчилгээ худалдан авахдаа харьцуулалтын аргаас зайлсхийж 763,397.7 мянган төгрөгийн шууд гэрээ байгуулсан;
- Цалингийн зардлаас 60,000.0 мянган төгрөгийг зориулалт бус зарцуулсан;
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж төсвөөс 133,147.0 мянган төгрөгийн гадаад томилолтын зардал гаргаж төсвийг үрэлгэн зарцуулсан зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 20 дугаар зүйлийн 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 15.2.7 заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

## **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн үйлчилгээний тариф 2013 оноос хойш шинэчлэгдээгүй нь өнөөгийн инфляц, үнийн өсөлт болон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний өөрчлөлттэй нийцэхгүй байна. Эрүүл мэндийн сайдын 2013 оны А/247 дугаар тушаалаар баталсан энэхүү тарифыг шинэчлээгүй нь мэргэжлийн өндөр түвшний шинжээчдийг ажиллуулах болон үйл ажиллагааг тогтвортой санхүүжүүлэхэд хүндрэл учруулах эрсдэл үүсгэж байна.

## **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаагчид бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Төсөл арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдах сургалтын зардалд лавлагаа шатлалын 3 эмнэлэгт 61,200.3 мянган төгрөг, 25 өрхийн эрүүл мэндийн төвд 50,000.0 мянган төгрөг, 7 аж ахуйн нэгжид 220,045.6 мянган төгрөг, 6 иргэнд 62,525.3 мянган төгрөг нийт 393,771.2 мянган төгрөгийг урьдчилан шилжүүлсэн байна.

## **Бусад асуудал**

Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн “Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах, бүтээмжийг сайжруулах тухай” 01 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх зорилгоор тус төвийн захирлын 2025 оны А/131 дүгээр тушаалаар нийт 10 орон тоог хасаж 8 алба 86 орон тоотой байхаар шинэчлэн баталсан байна.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *В.А.В.* Ц.НАРАНЧИМЭГ



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,103,901,889.11</b>	<b>582,891,532.83</b>
33	АВЛАГА	385,000.00	95,529,316.24
33300	Татаас, санхүүжилтийн авлага	385,000.00	34,329,000.00
33510	Байгууллагаас авах авлага	-	61,200,316.24
34	УРЬДЧИЛГАА	927,460,675.68	332,570,943.98
34600	Урьдчилж гарсан зардал	927,460,675.68	332,570,943.98
35	БАРАА МАТЕРИАЛ	176,056,213.43	154,791,272.61
35100	Түүхий эд материал	4,919,000.00	4,919,000.00
35110	Тусгай зориулалттай материал	3,014,000.00	3,014,000.00
35130	Эм боох материал	1,905,000.00	1,905,000.00
35400	Хангамжийн материал	171,137,213.43	149,872,272.61
35410	Бичиг хэргийн материал	17,082,460.00	15,665,860.00
35420	Аж ахуйн материал	7,942,044.00	11,465,594.00
35430	Сэлбэг хэрэгсэл	14,102,100.00	12,138,300.00
35440	Түлш, шатах тослох материал	2,517,403.66	668,761.84
35450	Барилгын засварын материал	7,688,500.00	8,732,400.00
35460	Хүнсний материал	5,681,500.00	131,500.00
35470	Бусад хангамжийн материал	116,123,205.77	101,069,856.77
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4,234,216,467.97</b>	<b>3,547,537,121.87</b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,234,216,467.97	3,547,537,121.87
39200	Биет хөрөнгө	3,060,944,599.20	2,488,043,919.74
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,620,745,734.71	1,620,851,526.71
39202	Хуримтлагдсан элэгдэл	(600,901,354.87)	(711,628,685.95)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	323,624,185.00	323,624,185.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(99,279,638.23)	(150,553,668.75)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	2,946,819,818.69	2,545,633,538.02
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,348,301,151.61)	(1,372,811,382.86)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	427,297,636.90	368,715,554.70
39208	Хуримтлагдсан элэгдэл	(216,664,631.35)	(145,561,091.50)
39214	Бусад үндсэн хөрөнгө	26,245,000.00	17,610,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(18,641,000.04)	(7,836,055.63)
39300	Биет бус хөрөнгө	1,173,271,868.77	1,059,493,202.13
39301	Програм хангамж	1,443,386,605.00	1,615,916,105.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(376,385,896.23)	(662,694,062.87)
39303	Бусад биет бус хөрөнгө	106,271,160.00	106,271,160.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2</b>	<b>5,338,118,357.08</b>	<b>4,130,428,654.70</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>22,678,400.00</b>	<b>65,806,597.00</b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	22,678,400.00	65,806,597.00
41300	Өглөг	22,678,400.00	65,806,597.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>5,315,439,957.08</b>	<b>4,064,622,057.70</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	5,315,439,957.08	4,064,622,057.70
51100	Засгийн газрын оруулсан капитал	2,390,485,153.08	2,390,485,153.08
51200	Хуримтлагдсан үр дүн	2,060,484,472.70	809,693,021.32
51210	Өмнөх үеийн үр дүн	255,166,876.52	2,060,510,920.70
51220	Тайлант үеийн үр дүн	1,805,317,596.18	(1,250,817,899.38)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	864,470,331.30	864,443,883.30
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5</b>	<b>5,338,118,357.08</b>	<b>4,130,428,654.70</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>33,955,903,066.43</b>	<b>33,232,316,944.89</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,432,365,179.43	33,232,316,944.89
120	Нийтлэг татварын бус орлого	1,432,365,179.43	823,736,174.89
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	532,882,648.23	567,534,327.89
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	422,954,401.00	465,756,431.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	109,928,247.23	101,777,896.89
120009	Бусад орлого	13,680,000.00	20,206,500.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	884,826,745.00	230,782,240.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	975,786.20	5,213,107.00
122	Тусламжийн орлого	-	32,408,580,770.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	32,408,580,770.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	31,939,570,600.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	-	31,939,570,600.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	469,010,170.00
122131	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	468,975,170.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	35,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	32,523,537,887.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	31,609,856,800.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	31,609,856,800.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	913,681,087.00	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	413,296,087.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500,000,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	385,000.00	-
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>32,137,542,054.29</b>	<b>34,465,051,002.28</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	32,137,542,054.29	34,465,051,002.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	31,491,162,169.97	32,957,543,281.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	22,196,009,778.13	24,323,655,784.08
210101	Үндсэн цалин	1,787,611,491.54	2,133,267,651.76
210102	Нэмэгдэл	625,618,250.08	576,310,744.51
210103	Унаа хоолны хөнгөлөлт	205,092,000.00	263,985,000.00
210104	Урамшуулал	240,940,660.00	216,580,393.00
210105	Гэрээт ажлын хөлс	19,336,747,376.51	21,133,511,994.81
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,669,763,878.61	3,135,285,814.46
210201	Тэтгэврийн даатгалын зардал	1,646,240,744.33	2,084,287,116.88
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	272,307,621.27	264,575,190.48
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	136,686,841.70	134,071,708.87
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	135,455,528.83	132,224,148.40
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	479,073,142.48	520,127,649.83
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	114,993,503.88	129,927,148.77
210301	Гэрэл, цахилгаан	61,077,220.59	71,391,124.79
210302	Түлш, халаалт	32,848,314.04	32,749,317.42

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210303	Цэвэр, бохир ус	21,067,969.25	25,786,706.56
2104	Хангамж, бараа материалын зардал	160,043,475.54	90,952,458.82
210401	Бичиг хэрэг	13,195,900.00	7,524,900.00
210402	Тээвэр, шатахуун	11,832,901.10	10,135,326.82
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,599,082.44	6,714,773.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	84,592,740.00	13,208,150.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,393,372.00	32,850,449.00
210408	Бараа материал акталсны зардал	21,429,480.00	-
210409	Бараа материал шилжүүлсний зардал	-	20,518,860.00
2105	Нормативт зардал	80,000.00	3,539,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	80,000.00	3,539,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	57,202,880.00	19,691,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,119,000.00	-
210604	Урсгал засвар	56,083,880.00	19,691,900.00
2107	Томилолт, зочны зардал	644,485,299.00	280,199,152.00
210702	Дотоод албан томилолт	644,485,299.00	280,199,152.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,272,662,812.45	492,065,254.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,228,174,803.45	408,452,385.00
210803	Даатгалын үйлчилгээ	106,920.00	2,306,920.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	269,208.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	27,222,136.00	63,577,609.00
210807	Газрын төлбөр	3,245,103.00	2,939,132.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	13,913,850.00	14,520,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,375,920,542.36	4,482,226,769.16
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,000,000.00	661,927,022.02
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,486,563,709.75	2,748,392,503.03
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	883,356,832.61	1,071,907,244.11
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	646,379,884.32	1,507,507,720.99
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	1,435,656,725.49
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	1,435,656,725.49
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	1,435,656,725.49
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	1,435,656,725.49
2132	Бусад урсгал шилжүүлэг	152,174,387.83	71,850,995.50
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	123,116,587.83	27,940,495.50
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	29,057,800.00	43,910,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	494,205,496.49	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	494,204,996.49	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	500.00	-
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>1,818,361,012.14</b>	<b>(1,232,734,057.39)</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>13,043,415.96</b>	<b>18,083,841.99</b>
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	13,043,415.96	18,083,841.99
<b>VII</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)</b>	<b>(13,043,415.96)</b>	<b>(18,083,841.99)</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)</b>	<b>1,805,317,596.18</b>	<b>(1,250,817,899.38)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>33,070,100,535.23</b>	<b>33,077,723,878.89</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	546,562,648.23	33,077,723,878.89
120	Нийтлэг татварын бус орлого	546,562,648.23	668,758,108.89
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	532,882,648.23	648,551,608.89
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	422,854,401.00	465,756,431.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	110,028,247.23	182,795,177.89
120009	Бусад орлого	13,680,000.00	20,206,500.00
122	Тусламжийн орлого	-	32,408,965,770.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	32,408,965,770.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	31,939,570,600.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	-	31,939,570,600.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	469,395,170.00
122131	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	468,975,170.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	420,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	32,523,537,887.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	31,609,856,800.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	31,609,856,800.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	913,681,087.00	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	413,296,087.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500,000,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	385,000.00	-
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>31,738,855,726.71</b>	<b>33,064,973,878.89</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	31,738,855,726.71	33,064,973,878.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	31,091,825,342.39	31,523,137,157.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	22,018,817,717.40	24,363,084,837.06
210101	Үндсэн цалин	1,479,617,211.83	1,729,304,363.47
210102	Нэмэгдэл	638,159,685.94	932,987,876.67
210103	Унаа хоолны хөнгөлөлт	215,055,515.50	263,504,040.98
210104	Урамшуулал	218,656,283.27	303,776,561.13
210105	Гэрээт ажлын хөлс	19,467,329,020.86	21,133,511,994.81
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,846,196,300.00	3,095,856,761.48
210201	Тэтгэврийн даатгалын зардал	1,759,216,700.00	2,061,356,063.98
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	270,099,500.00	261,697,347.89
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	140,901,500.00	131,388,593.39
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	135,049,700.00	129,722,934.00
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	540,928,900.00	511,691,822.22
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	114,993,503.88	130,577,148.77
210301	Гэрэл, цахилгаан	61,077,220.59	71,391,124.79
210302	Түлш, халаалт	32,848,314.04	32,749,317.42
210303	Цэвэр, бохир ус	21,067,969.25	26,436,706.56
2104	Хангамж, бараа материалын зардал	63,646,375.44	49,027,433.00
210401	Бичиг хэрэг	10,940,800.00	4,026,800.00
210402	Тээвэр, шатахуун	6,435,300.00	6,420,600.00

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,552,082.44	6,654,773.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал,ариутгал	18,035,400.00	15,753,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,682,793.00	16,172,260.00
2105	Нормативт зардал	1,048,500.00	4,189,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	3,539,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,048,500.00	650,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	70,361,670.00	22,635,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	18,209,090.00	2,075,200.00
210604	Урсгал засвар	52,152,580.00	20,560,300.00
2107	Томилолт, зочны зардал	650,833,426.00	281,913,130.00
210702	Дотоод албан томилолт	650,833,426.00	281,913,130.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,хураамж	1,478,348,523.56	397,032,077.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээнийтөлбөр хураамж	1,273,426,014.56	313,652,608.00
210803	Даатгалын үйлчилгээ	106,920.00	2,306,920.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	291,208.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	187,001,636.00	63,322,209.00
210807	Газрын төлбөр	3,245,103.00	2,939,132.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	14,568,850.00	14,520,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,847,579,326.11	3,178,821,270.59
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,000,000.00	830,090,270.02
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,841,579,326.11	2,348,731,000.57
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	647,030,384.32	1,541,836,720.99
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	1,469,985,725.49
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	1,469,985,725.49
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруутөвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	1,469,985,725.49
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийнзардал\	-	1,435,656,725.49
2131125	Төсвийн дансны авлагад тооцох төвлөрүүлэхшилжүүлгийн зардал	-	15,745,300.00
2131126	Нэмэлт санхүүжилтийн дансны авлагад тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	18,583,700.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	152,439,887.83	71,850,995.50
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	123,116,587.83	27,940,495.50
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	29,323,300.00	43,910,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	494,590,496.49	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	494,204,996.49	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	385,500.00	-
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>1,331,244,808.52</b>	<b>12,750,000.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,331,263,135.00</b>	<b>12,750,000.00</b>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,331,263,135.00	12,750,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,331,263,135.00	12,750,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,331,263,135.00	12,750,000.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(1,331,263,135.00)</b>	<b>(12,750,000.00)</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>(18,326.48)</b>	<b>-</b>
<b>101</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>18,326.48</b>	<b>-</b>
<b>20</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,390,485,153.08	864,470,331.30	255,166,876.52	3,510,122,360.90
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,390,485,153.08	864,470,331.30	255,166,876.52	3,510,122,360.90
Тайлант үеийн үр дүн	-	-	1,805,317,596.18	1,805,317,596.18
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,390,485,153.08	864,470,331.30	2,060,484,472.70	5,315,439,957.08
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,390,485,153.08	864,470,331.30	2,060,484,472.70	5,315,439,957.08
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	26,448.00	26,448.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,390,485,153.08	864,470,331.30	2,060,510,920.70	5,315,466,405.08
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	(26,448.00)	-	(26,448.00)
Тайлант үеийн үр дүн	-	-	(1,250,817,899.38)	(1,250,817,899.38)
2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,390,485,153.08	864,443,883.30	809,693,021.32	4,064,622,057.70

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	32,725,940,200.00	31,152,465,483.40	1,573,474,716.60	95.2
12	Татварын бус орлого	32,725,940,200.00	31,152,465,483.40	1,573,474,716.60	95.2
120	Нийтлэг татварын бус орлого	510,200,000.00	648,551,608.89	(138,351,608.89)	127.1
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	410,200,000.00	465,756,431.00	(55,556,431.00)	113.5
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	100,000,000.00	182,795,177.89	(82,795,177.89)	182.8
122	Тусламжийн орлого	32,215,740,200.00	30,503,913,874.51	1,711,826,325.49	94.7
122005	Төсвөөс санхүүжих	32,215,740,200.00	30,503,913,874.51	1,711,826,325.49	94.7
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	32,725,940,200.00	31,136,720,183.40	1,589,220,016.60	95.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	32,725,940,200.00	31,136,720,183.40	1,589,220,016.60	95.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	32,622,774,200.00	31,085,075,687.90	1,537,698,512.10	95.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	25,678,412,800.00	24,363,084,837.06	1,315,327,962.94	94.9
210101	Үндсэн цалин	1,620,094,300.00	1,729,304,363.47	(109,210,063.47)	106.7
210102	Нэмэгдэл	920,413,500.00	932,987,876.67	(12,574,376.67)	101.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	223,597,400.00	263,504,040.98	(39,906,640.98)	117.8
210104	Урамшуулал	381,733,400.00	303,776,561.13	77,956,838.87	79.6
210105	Гэрээт ажлын хөлс	22,532,574,200.00	21,133,511,994.81	1,399,062,205.19	93.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,160,728,800.00	3,095,856,761.48	64,872,038.52	97.9
210201	Тэтгэврийн даатгал	2,107,837,500.00	2,061,356,063.98	46,481,436.02	97.8
210202	Тэтгэмжийн даатгал	263,384,800.00	261,697,347.89	1,687,452.11	99.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	131,584,200.00	131,388,593.39	195,606.61	99.9

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210204	Ажилгүйдлийн даатгал	131,584,200.00	129,722,934.00	1,861,266.00	98.6
210205	Эрүүл мэндийн даатгал	526,338,100.00	511,691,822.22	14,646,277.78	97.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	134,847,700.00	130,577,148.77	4,270,551.23	96.8
210301	Гэрэл, цахилгаан	72,396,200.00	71,391,124.79	1,005,075.21	98.6
210302	Түлш, халаалт	30,878,100.00	32,749,317.42	(1,871,217.42)	106.1
210303	Цэвэр, бохир ус	31,573,400.00	26,436,706.56	5,136,693.44	83.7
2104	Хангамж, бараа материалын зардал	53,894,100.00	49,027,433.00	4,866,667.00	91.0
210401	Бичиг хэрэг	8,150,100.00	4,026,800.00	4,123,300.00	49.4
210402	Тээвэр, шатахуун	6,420,600.00	6,420,600.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,760,100.00	6,654,773.00	2,105,327.00	76.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	14,471,500.00	15,753,000.00	(1,281,500.00)	108.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,091,800.00	16,172,260.00	(80,460.00)	100.5
2105	Нормативт зардал	4,784,500.00	4,189,000.00	595,500.00	87.6
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,844,100.00	3,539,000.00	305,100.00	92.1
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	940,400.00	650,000.00	290,400.00	69.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,875,300.00	22,635,500.00	239,800.00	99.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,315,000.00	2,075,200.00	239,800.00	89.6
210604	Урсгал засвар	20,560,300.00	20,560,300.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	311,990,400.00	281,913,130.00	30,077,270.00	90.4
210702	Дотоод албан томилолт	311,990,400.00	281,913,130.00	30,077,270.00	90.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	487,335,100.00	409,782,077.00	77,553,023.00	84.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	376,903,000.00	313,652,608.00	63,250,392.00	83.2
210803	Даатгалын үйлчилгээ	2,307,900.00	2,306,920.00	980.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	376,500.00	291,208.00	85,292.00	77.3
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	79,700.00	-	79,700.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	76,073,200.00	76,072,209.00	991.00	100.0
210807	Газрын төлбөр	3,019,800.00	2,939,132.00	80,668.00	97.3
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	28,575,000.00	14,520,000.00	14,055,000.00	50.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,767,905,500.00	2,728,009,800.59	39,895,699.41	98.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	850,000,000.00	830,090,270.02	19,909,729.98	97.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,917,905,500.00	1,897,919,530.57	19,985,969.43	99.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	103,166,000.00	51,644,495.50	51,521,504.50	50.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	103,166,000.00	51,644,495.50	51,521,504.50	50.1
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	78,962,000.00	27,940,495.50	51,021,504.50	35.4
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	24,204,000.00	23,704,000.00	500,000.00	97.9
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	15,745,300.00	(15,745,300.00)	100.0

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	(15,745,300.00)	15,745,300.00	100.0
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	(15,745,300.00)	15,745,300.00	100.0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	4255	158	4097	3.7
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		100.0
610001	Төсвийн байгууллага	1	1		100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	2127	2120	7	99.7
620001	Удирдах ажилтан	10	8	2	80.0
620002	Гүйцэтгэх ажилтан	68	67	1	98.5
620003	Үйлчлэх ажилтан	8	4	4	50.0
620004	Гэрээт ажилтан	2041	2041		100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	2127	2120	7	99.7
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	2041	2041		100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	86	79	7	91.9

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>469,395,170.00</b>
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	469,395,170.00
Тусламжийн орлого	469,395,170.00
Хандив тусламж /дотоод/	469,395,170.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	469,395,170.00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	439,336,120.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	30,059,050.00
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>450,811,470.00</b>
УРСГАЛ ЗАРДАЛ	450,811,470.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	450,811,470.00
Бараа үйлчилгээний бусад зардал	450,811,470.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	450,811,470.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Эрүүл мэндийн салбарын хөгжлийн бодлого, хууль эрх зүйн баримт бичиг, стандарт, удирдамжийг боловсруулахад шийдвэр гаргагчдыг нотолгоо, дүн шинжилгээг тоо мэдээллээр хангаж, эрүүл мэндийн ажилтан, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах үйл ажиллагаа болон амбулаторийн үзлэгийн цаг товлох үйлчилгээг үндэсний хэмжээнд зохицуулж холбогдох хууль, тогтоомж, тушаал, шийдвэрийг хэрэгжүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Дээрх зорилтын хүрээнд үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эрүүл мэндийн бодлого, тогтолцооны судалгаа, нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн тусламж үйлчилгээний бодлогод дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн төслийн нөхцөл байдлын дүн шинжилгээ, нөлөөллийн үнэлгээ, эрүүл мэндийн үндэсний тооцоо, эдийн засгийн дүн шинжилгээ хийх;
- Эрүүл мэндийн статистик мэдээ, мэдээлэл, цахим эрүүл мэнд, мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэх ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулах;
- Эрүүл мэндийн ажилтны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх;
- Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх замаар тусламж үйлчилгээний чанарыг баталгаажуулах;
- Донорын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах үйл ажиллагааг үндэсний хэмжээнд зохицуулж, бодлого, арга зүйгээр хангах, хяналт тавих, үр дүнг тооцох;
- Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг болон тусгай мэргэжлийн төвийн амбулаторийн үзлэгийн цаг товлох үйлчилгээний үйл ажиллагааны уялдааг зохицуулах, хангах;

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Эрүүл мэндийн хөгжлийн төв нь Монгол Улсын үндсэн хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн эрүүл мэндийн салбарын бодлогыг зохицуулах, хэрэгжүүлэх үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт;
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт өөрчлөлт;
- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ыг шинэчлэн баталсан;
- Захирлын 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн А/99 дүгээр тушаалаар Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн баталсан;

Удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй гэж үзлээ.

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Хяналт шинжилгээ, үнэлгээний албанаас 2025 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Тус төв нь дотоод аудитын нэгжгүй бөгөөд Эрүүл мэндийн яамны Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газрын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/590 дүгээр тушаалаар баталсан НБББББ нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,207,689.7 мянган төгрөгөөр буюу 22.6 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	385.0	95,529.3	95,144.3
Урьдчилгаа	927,460.7	332,570.9	(594,889.7)
Бараа материал	176,056.2	154,791.3	(21,264.9)
Үндсэн хөрөнгө	4,234,216.5	3,547,537.1	(686,679.3)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>5,338,118.4</b>	<b>4,130,428.7</b>	<b>(1,207,689.7)</b>
Өр төлбөр	22,678.4	65,806.6	43,128.2
<b>Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/</b>	<b>5,315,440.0</b>	<b>4,064,622.1</b>	<b>(1,250,817.9)</b>
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>5,338,118.4</b>	<b>4,130,428.7</b>	<b>(1,207,689.7)</b>

Авлагын дансны үлдэгдэл 95,529.3 мянган төгрөгт хүрч өмнөх оноос 95,144.3 мянган төгрөгөөр өсөхөд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах сургалтын төлбөрт Улсын нэгдүгээр төв эмнэлэгт 21,219.5 мянган төгрөг, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд 34,752.0 мянган төгрөг, Гэмтэл согог судлалын үндэсний төвд 5,228.8 мянган төгрөг шилжүүлсэн, Сангийн яаманд төвлөрүүлсэн 18,583.7 мянган төгрөгийн татаас санхүүжилтийн авлагаар нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Урьдчилж төлсөн зардал дансны үлдэгдэл 332,570.9 мянган төгрөгт хүрч өмнөх оноос 594,889.7 мянган төгрөгөөр буурахад Дижитал медик ХХК программ хангамж 159,779.5 мянган төгрөгийн шинэчлэлийг хүлээн авсан, “Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн хүрээнд Сэтгэцийн эрүүл мэндийн төвийн 150,000.0 мянган төгрөг, томуу, томуу төст өвчний идэвхжилийн үед үзүүлэх яаралтай тусламжийн 88,389.6 мянган төгрөг, САГ-2026/357/НА-СТА-ТШЗ

гадаад сургалтад 2024 онд хамрагдаж 2025 онд төгссөн хамрагдсан эмч, мэргэжилтэн нарын байр хоолны 481,722.7 мянган төгрөгийн зардлыг гүйцэтгэлээр хүлээн зөвшөөрч бүртгэсэн нь голлон нөлөөлсөн байна.

Бараа материал дансны үлдэгдэл 154,791.3 мянган төгрөгт хүрч өмнөх оноос 21,264.9 мянган төгрөгөөр буурахад тайлант онд худалдан авсан 131,459.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, байгууллагын үйл ажиллагаанд зарцуулсан 137,406.4 мянган төгрөг, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 173 дугаар тогтоолоор Улсын хоёрдугаар төв эмнэлэгт 20,518.9 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, хангамжийн материал шилжүүлсэн нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансанд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 12,750.0 мянган төгрөг, өмнөх оны авлагаас 159,779.5 мянган төгрөгөөр программ хангамжид шинэчлэл хийсэн, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийн үнийг 230,782.2 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосноор тус тус нэмэгдэж, дахин үнэлгээний хорогдол 581,378.8 мянган төгрөг, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 173 дугаар тогтоолоор Улсын хоёрдугаар төв эмнэлэгт 30 нэр төрлийн нийт 117,700.9 мянган төгрөгийн хөрөнгийг данс хооронд шилжүүлсэн дүнгээр хасагдсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 65,806.6 мянган төгрөгт хүрч өмнөх оноос 43,128.2 мянган төгрөгөөр өсөхөд “Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн хүрээнд сургалтын төлбөрт Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуульд 21,897.6 мянган төгрөг, Хавдар судлалын үндэсний төвд 19,220.5 мянган төгрөгийн өглөгтэй нь голлон нөлөөлсөн байна.

#### Программ хангамжийн талаарх судалгааны үр дүн:

Эрүүл мэндийн статистик бүртгэл, ажилтын нэгдсэн бүртгэл, сургалттай холбоотой эрүүл мэндийн статистик мэдээллийн 1313.mn, статистик бүртгэлийн программ /Health info/, Н Info-VHS эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх программ зэрэг 662,406.0 мянган төгрөгийн 9 программ, нягтлан бодох бүртгэлийн 1,500.0 мянган төгрөгийн “Dynamic” программ бүртгэлтэй байна. Health info, эрүүл мэндийн ажилтны нэгдсэн бүртгэлийн сан, эрүүл мэндийн статистик мэдээллийн 1313.mn программд 937,779.5 мянган төгрөгийн хөгжүүлэлт, шинэчлэл хийгдэж, жилийн эцсийн байдлаар 1,615,916.1 мянган төгрөгийн биет бус хөрөнгийн дансанд үлдэгдэлтэй байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 33,514,000.0 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 500,000.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлэхээр, нийт зарлагыг 34,014,000.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 54,125.0 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлыг 52,690.1 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардлыг 52,082.4 мянган төгрөг, томилолт зочны зардлыг 35,701.2 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 207,784.9 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 64,298.8 мянган төгрөгөөр тус тус бууруулж, нийт зардлыг 33,547,317.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 821,377.4 мянган төгрөгөөр бууруулж, нийт 2 удаа тодотгосон байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн хүрээнд 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 32,215,740.2 мянган төгрөгийг улсын төсвөөс, 510,200.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 30,503,913.9 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 648,551.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 31,136,720.2 мянган төгрөг буюу 95.1 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 81,011.4 мянган төгрөг, дадлагажигч эмч бэлтгэх зардлын төсвийг 1,363,397.2 мянган төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмжийн зардлыг 51,521.5 мянган төгрөг, төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх зардлыг 19,985.0 мянган төгрөг, Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх зардлыг 62,771.1 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	/мянган төгрөгөөр/		
				Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71602	<b>Эмнэлгийн тусламж үйлчилгээ</b>	<b>25,497,896.7</b>	<b>24,134,499.4</b>	<b>1,363,397.2</b>	<b>94.7</b>
2	81569	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	101,120.6	101,120.6	-	100.0
3	81610	Дадлагажигч эмч бэлтгэх	25,396,776.1	24,033,378.9	1,363,397.2	94.6
4	71603	<b>Эрүүл мэндийн бодлого, удирдлага</b>	<b>7,228,043.5</b>	<b>7,002,220.8</b>	<b>225,822.7</b>	<b>96.9</b>
5	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	5,358,572.8	5,277,561.4	81,011.4	98.5
6	80219	Харуул, хамгаалалтын зардал	79,103.8	79,051.9	51.9	99.9
7	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	103,166.0	51,644.5	51,521.5	50.1
8	81519	Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх	1,047,316.5	1,027,331.5	19,985.0	98.1
9	81563	Цахим бодлогын арга хэмжээ	456,246.2	445,764.3	10,481.9	97.7
10	81569	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	183,638.2	120,867.1	62,771.1	65.8

Зарцуулаагүй төсвийн үлдэгдэл 1,451,402.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

#### 1. Байгууллагуудын орон тооны цомхотголын талаар

Тус байгууллагын орон тоог 96, гэрээт ажилтан 2041 байхаар баталж 25,678,412.8 мянган төгрөгийн цалингийн зардлыг төлөвлөсөн байна. Эрүүл мэндийн сайдын Чиглэл хүргүүлэх тухай 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 1а/3266 дугаар албан бичиг, Эрүүл мэндийн сайдын хэрэгжилтийг хангаж ажиллах тухай 2025 оны 7 сарын 04-ний өдрийн 1а/3546 дугаар албан бичгийн дагуу үйл ажиллагааны хувьд уялдаатай нэгж, албыг нэгтгэн чиг үүргийн давхардлыг арилган орон тоог бууруулж, төвийн дүрэм, зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн боловсруулж 8 алба, 86 орон тоотойгоор зохион байгуулсны үр дүнд, гүйцэтгэлээр цалингийн зардлыг 1,315,327.9 мянган төгрөгийг хэмнэсэн байна.

#### 2. Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын тарифын талаар:

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2025 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А/156 дугаар тушаалаар ажлын нэг өдрийн хоолны зардлыг 23.0 мянган төгрөг, унааны зардлыг 2.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоож тайлант хугацаанд хоолны зардалд 229,294.0 мянган төгрөг, унааны зардалд 34,210.0 мянган төгрөг, нийт 263,504.0 мянган төгрөгийг олгосон байна.

### *3. Гадаад томилолт, арга хэмжээний судалгааны үр дүн*

Тайлант онд БНСУ-аас 14 профессор урин эмчилгээ, оношилгооны чиглэлээр үзлэг, оношилгоо явуулахад 77,793.9 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 69,422.3 мянган төгрөг зарцуулсан. Мөн БНТУ, БНХАУ, БНСУ-д 6 удаагийн санамж бичиг, хамтын ажиллагаанд 109,015.9 мянган төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 106,449.5 мянган төгрөг зарцуулсан байна.

### *4. Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний судалгааны үр дүн:*

Магадлан итгэмжлэлийн зөвлөлийн гишүүдийн уулзалт болон гадна дотоодын мэргэжилтэн, зөвлөхтэй уулзалттай холбоотой 21 арга хэмжээнд 4,867.6 мянган төгрөгийн зардал батлагдсанаас 4,867.6 мянган төгрөг, гадаад улсад зохион байгуулагдах 21 удаагийн сургалтад 1,035,450.0 мянган төгрөг батлагдсанаас 16 удаагийн сургалтад 716,541.5 мянган төгрөг, мөн дотоодод зохион байгуулагдах 43 удаагийн сургалтад 568,050.0 мянган төгрөгийн зардал батлагдсанаас гүйцэтгэлээр 22 арга хэмжээнд 303,566.1 мянган төгрөгийг тус тус зарцуулсан.

Гадаад сургалттай холбоотой төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулсан 133,147.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн

### *5. Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ, төлбөрийн судалгааны үр дүн*

Тайлант хэвлэл мэдээллийн байгууллагуудтай гэрээ байгуулаагүй төсвөөс зардал гараагүй, удирдлагын буруутай шийдвэрээр төрд учирсан хохирол байхгүй.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас эрүүл мэндийн салбарын хүний хөгжлийг дэмжих, шинжилгээ судалгаанд 179,734.1 мянган төгрөг, Нэгдсэн Үндэстний Байгууллагаас “100-Эрүүл мэнд”төсөл, зүрхний эмгэг судалгаанд 267,930.0 мянган төгрөг, зүрх судлал, телемедицин төслөөс 21,060.9 мянган төгрөг, өмнөх оны үлдэгдлээс 350.0 мянган, бусад 320.2 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, төсөл арга хэмжээнд 450,811.5 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 18,583.7 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

#### **3.5.3.1 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн нэмэлт санхүүжилтийн дансанд хандив тусламжаар 7 төсөл арга хэмжээнд зориулж 469,395.2 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож 6 төсөл арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж дууссан байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилт хувь	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	Хүн амын эрүүл мэндийн эрсдэл, эмзэг байдлын шинжилгээ, судалгааны статистик мэдээллийг боловсруулах	2025 он	Монгол улсын хүн амын эрүүл мэндийн эмзэг байдлын шинжилгээ” судалгааг хүн амын эрүүл мэндэд нөлөөлж буй нийгэм эдийн засаг, дэд бүтэц, хүрээлэн буй орчин, цаг агаар, уур амьсгалын үзүүлэлтийг эрүүл мэндийн үзүүлэлтүүдтэй холбон харьцуулах	100 хувь	1,009.1	1,009.1
2	Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжлийг дэмжих 2025-2028 оны цогц арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах	2025 он	Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050” болон Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд эрүүл мэндийн хүний нөөцийн хангалт, ур чадвар, нийгмийн хамгааллыг сайжруулах, хүн амын хэрэгцээ, тусламж үйлчилгээний зохион байгуулалт төлөвлөлттэй уялдуулан хүний нөөцийг бэлтгэх, эмч, эмнэлгийн ажилтны цалин хөлс, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох	100 хувь	55,067.2	55,067.2
3	Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн өмнөх ба төгсөлтийн дараах сургалтын тооцоог боловсронгуй болох	2025 он	Эрүүл мэндийн мэргэжилтэн бэлтгэх сургалтын тогтолцоог шинэчлэх, салбарын хүний нөөцийн мэдлэг, ур чадварыг сайжруулах	100 хувь	79,828.2	79,828.2
4	Эрүүл мэндийн байгууллагуудын нийгмийн эрүүл мэндийн ажилтныг бэлтгэх, чадавхижуулах богино, дунд, урт хугацааны сургалтын хөтөлбөр боловсруулах	2025 он	Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг дэмжих, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тогтолцоог сайжруулахад хүний нөөцийг бэлтгэхэд мэргэшүүлэх болон мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийг шинээр болон шинэчлэн боловсруулахад оршино.	100 хувь	44,375.0	44,375.0
5	Хэрлэгийн гаралтай зүрхний эмгэгийн эрсдэлт хүчин зүйлсийн судалгаа	2025 он	Хүүхдийн дунд хэрэхийн гаралтай цочмог халууралт өвчин болон хэрэхийн гаралтай зүрхний өвчний эрсдэлт хүчин зүйлсийг тодорхойлох.	100 хувь	84,030.0	84,030.0
6	100-Эрүүл мэнд	2025 он	Олон нийтийн эрүүл мэндийн ажилтнууд болон иргэдэд эрүүл мэндийн мэдээлэл, зааварчилгааг хүртээмжтэй, ойлгомжтой, цахим хэлбэрээр хүргэж, хүүхдийн эрүүл мэндийн боловсролыг сайжруулах, урьдчилан сэргийлэх үйлчилгээг дэмжихэд чиглэгдсэн аппликэйшныг бий болгох хэрэглээнд нэвтрүүлэх.	90 хувь	183,900.0	165,316.3
7	Хүн амын өвчлөл, нас баралтын бүртгэл, мэдээллийн чанарыг сайжруулах үйл ажиллагаа		Зүрх судасны тогтолцооны өвчний статистик мэдээллийг боловсронгуй болгох, эрүүл мэндийн дата мэдээллийн сан бүрдүүлэх	100 хувь	21,060.9	21,060.9
	<b>Нийт дүн</b>				469,270.4	450,686.7

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажлын төлөвлөгөөнд 165,280.0 мянган төгрөгийн 5 арга хэмжээг харьцуулалтын аргаар авахаар баталсны дагуу харуул хамгаалалтын үйлчилгээ авах 98,662.0 мянган төгрөгийн худалдан авалтыг хийж, бусад 4 арга хэмжээ нь төсвийн санхүүжилттэй холбоотой худалдан авалт хийгдээгүй байна.

Тайлант онд батлагдсан төсвийн хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд: Эрүүл мэндийн сайдын 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн А/236 дугаар тушаалаар баталсан "Эрүүл Монгол хүн" үндэсний хөдөлгөөний 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн хүрээнд 12 аж ахуйн нэгж, байгууллагатай 615,244.0 мянган төгрөгийн, үйл ажиллагааны зардлаас 2 төрийн бус байгууллагатай 148,153.8 мянган төгрөгийн, нийт 763,397.7 мянган төгрөгийн гэрээг байгуулж, сонгон шалгаруулалт явуулаагүй, шууд худалдан авалт хийсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д "Хуульд өөрөөр заагаагүй бол худалдан авах ажиллагааг зохион байгуулах, мэдээлэл солилцох, мэдээллийн ил тод байдлыг хангах ажиллагааг цахим системээр гүйцэтгэнэ" мөн хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолын хавсралтад "Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 20,000.0 мянган төгрөг" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас давсан ажил үйлчилгээг шууд худалдан авсан зөрчлийг таслан зогсоож, цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор М.Пагамдулам, аудитор Ж.Бямбацогт нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг аудитын менежер В.Эрдэнэцогт, дараагийн шатны хяналтыг газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 74 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 32,523,537.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 325,235.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Эрүүл мэндийн хөгжлийн төв нь тайлант онд цахим гарын үсэг, цахим платформ ашиглах зэргээр үндсэн үйл ажиллагааны зардлыг 87,952.9 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

Тайлант онд батлагдсан төсвийн хүрээнд төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрүүл мэндийн сайдын 2024 оны 7 дугаар сарын 03-ний өдрийн А/316 дугаар тушаалаар БНТУ-д эрүүл мэндийн байгууллагуудын удирдах ажилтныг чадавхжуулах сургалтад ЭМС болон 25 эмнэлгийн байгууллагын удирдах албан тушаалтнууд оролцож онгоцны тийзэд 62,049.0 мянган төгрөг, томилолтын зардалд 71,098.3 мянган төгрөг, нийт 133,147.0 мянган төгрөгийн гадаад томилолтын зардал гаргаж төсвийг үрэлгэн зарцуулсан.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг үрэлгэн зарцуулсан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд байршуулбал зохих мэдээллээс “төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, эдийн засгийн ангилал”-тай холбоотой 1 мэдээллийг хугацаа хоцроож, бусад мэдээллийг бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 2 улирлын санхүүгийн тайланг хамруулж, бараа материал, бусад эргэлтийн хөрөнгө, мөнгөн хөрөнгийн данстын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажуулсан. Завсрын аудитаар 1,404,960.8 мянган төгрөгийн 6 зөвлөмж өгснөөс жилийн эцсийн аудитаар дахин үнэлж үзэхэд бүрэн хэрэгжүүлсэн байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2,263.8 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт, 981,077.0 мянган төгрөгийн 11 албан шаардлага, 794,451.9 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн нь 100.0 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	3	2,263.8	3	2,263.8	100.0
Албан шаардлага	11	981,077.0	11	981,077.0	100.0
Зөвлөмж	3	794,451.9	3	794,451.9	100.0
<b>Нийт дүн</b>	<b>17</b>	<b>1,777,792.7</b>	<b>17</b>	<b>1,777,792.7</b>	<b>100.0</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-г бүрэн хэрэгжүүлж байгааг шалгах.
2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах хуулийн холбогдох заалтын дагуу зохион байгуулсан эсэхийг нарийвлан шалгахад анхаарлаа хандуулах шаардлагатай гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 381,992.6 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 381,992.6 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

*Залруулсан алдаа:*

- Эрүүл монгол хөтөлбөрийн хүрээнд сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан олон нийтийн эрүүл мэндийн ажилтан бэлтгэх сургалтын 4,680.0 мянган төгрөгийн томилолтын урьдчилгааг жилийн эцэст олгоод урьдчилж гарсан зардал дансаар дамжуулан зардлаар бүртгэсэн;
- Авлагын тооцоо дансанд бүртгэж байсан гүйгээг жилийн эцэст өглөгийн дансанд шилжүүлэн тохируулах бичилт хийгээгүйгээс авлага дансыг 56,089.3 мянган төгрөгөөр хасах үлдэгдэлтэй тайлагнасан;
- Хувь хүнд өгөх өглөг, авлагын тооцоог үүсгэлгүй 321,223.3 мянган төгрөгийн томилолтын урьдчилгаа олгоод зардал дансанд хаасан;

Энэ нь УСНББОУС-1-ийн 27-д “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал ба нөхцөл байдлуудыг үзэл баримтлалд заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурт нийцүүлэн үнэн зөв илэрхийлэхийг шаарддаг” гэсэнтэй нийцээгүй, санхүүгийн тайлагналын толилуулга батламж мэдэгдлийг хангаагүй.

Аудитаар нийт 1,087,359.5 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 14,360.5 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 1,072,999.0 мянган төгрөгийн 7 албан шаардлага хүргүүлээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 1,087,359.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 762,124.1 мянган төгрөгөөр давсан тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

1. Тагнуулын ерөнхий газрын шийдвэргүй захиргаа, санхүү, удирдлагын албаны ахлах мэргэжилтэнд тус төвийн захирлын 2020 оны Б/06 дугаар тушаалаар нууцын нэмэгдлийг 20 хувиар тооцож 4 сар хүртэл 1,360.5 мянган төгрөгийн нэмэгдэл олгосон байна. Энэ нь Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2-т “Нууц хамгаалах ажилтанд харьцаж байгаа нууцын зэрэглэл, нууцтай ажилласан хугацааг харгалзан Засгийн газраас тогтоосон журмын дагуу цалингийн нэмэгдэл олгоно”, Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Нууц хамгаалах ажилтанд цалингийн нэмэгдэл олгох журам”-ын 1.2-т “Нууц хамгаалах ажилтнаар тагнуулын байгууллагын Аюулгүй байдлын шалгалтад хамрагдаж тэнцсэн хүнийг тухайн байгууллагын удирдлагын шийдвэрээр томилно”, 4.1-т “Нууц хамгаалах ажилтнаас бусад нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтанд нууц хамгаалах ажилтны цалингийн нэмэгдэл олгохыг хориглоно” гэж тус тус заасантай нийцээгүй байна

Шийдвэрлэсэн нь: Холбогдох байгууллагын шийдвэргүй олгосон нэмэгдэл 1,360.5 мянган төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Захирлын 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн "Урамшуулал олгох тухай" А/199 дүгээр тушаалын 3 дугаар хавсралтаар 13 албан хаагчийг 13,000.0 мянган төгрөгийн захирлын нэрэмжит шагналаар, цалингийн сангаас шагнасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэж тус тус заасантай нийцээгүй

Шийдвэрлэсэн нь: Цалингийн сангаас зориулалт бусаар, үрэлгэн зарцуулсан 13,000.0 мянган төгрөгийг буруу шийдвэр гаргасан албан тушаалтнаар нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

## 5.2 Албан шаардлага

1. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн "Урамшуулал олгох тухай" А/199 дүгээр тушаалаар "Шилдэг алба, албан хаагчдад олгох мөнгөн урамшуулал"-д 60,000.0 мянган төгрөгийн шагналыг цалингийн сангаас гаргаж зориулалт бус зарцуулсан. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3-т "хуульд нийцээгүй шийдвэр гаргах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн А/99 дүгээр тушаалаар баталсан Хөдөлмөрийн дотоод журмын 8.2-д "Ажил олгогч нь ажилтанд төрийн алба хаасан хугацааны, эрдмийн зэрэг, цолны, мэргэшлийн зэргийн, ур чадвар оны нууцын ажилтны, эрх бүхий албан тушаалтны, хоол унааны нэмэгдлийг болон илүү цагаар ажиллуулсан нэмэгдэл хөлс, бусад шагнал урамшууллыг холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын шийдвэр, хөдөлмөрийн болон хамтын гэрээний холбогдох заалтыг үндэслэн, захирлын тушаалаар олгоно" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цалингийн сангаас зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

2. Дотоод албан томилолтын хуудасгүй болон ирсэн явсан өдрийн тэмдэглэгээ хийгээгүй бүрэн баталгаажуулаагүй, анхан шатны бүрдэл дутуу баримтаар 58,068.3 мянган төгрөгийн томилолтын зардал олгосон. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил, гүйлгээг бүртгэж, санхүүгийн тайланд тусгасан зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

3. Жилийн эцэст ажил, үйлчилгээ гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан 4 аж ахуйн нэгж, байгууллагатай 25,754.0 мянган төгрөгийн авлагын үлдэгийн тооцоог нийлж, актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Жилийн эцэст авлагын үлдэгдлийг харилцагч байгууллагатай тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

4. Эрүүл мэндийн төвийн захирлын 2025 оны А/103 дугаар тушаалаар 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд нягтлан бодох бүртгэлийн хөтлөлтийн чанар,

үр дүнгээр сайн үнэлэгдсэн гэсэн үндэслэлээр санхүүгийн 4 албан хаагчид, нийт 21,693.6 мянган төгрөгийн урамшууллыг олгосон нь ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргээ биелүүлснийг дүгнэж олгодог улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т "Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно" гэсэн заалттай тус тус нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Мөнгөн урамшуулалыг давхардуулан олгосон зөрчлийг таслан зогоох албан шаардлага хүргүүлээ.

5. Эрүүл мэндийн төвийн захирлын 2025 оны 10 сарын 20-ны өдрийн А/158 дугаар тушаалаар "Монголын эрчимт дасгалын холбоо" төрийн бус байгууллагатай 2025 оны 10 сарын 20-ны өдөр 122 дугаар гэрээ байгуулж, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Шанхай хотод зохион байгуулагдах "Кроссфит Азийн аварга шалгаруулах" үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг үзүүлж "Монголын эрчимт дасгалын холбоо" ТББ-д 10,938.4 мянган төгрөгийн шилжүүлж, зориулалт бус зарцуулсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 25 дугаар зүйлийн 25.10-т "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6-д "үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх" гэсэн заалттай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалт бус зарцуулдаг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Эрүүл монгол хөтөлбөрийн хүрээнд сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан олон нийтийн эрүүл мэндийн ажилтан бэлтгэх сургалтын томилолтын урьдчилгааг жилийн эцэст олгоод урьдчилж гарсан зардал дансаар дамжуулан зардлаар бүртгэсэн	1	4,680.0			1	4,680.0	1	4,680.0				
2	Авлагын тооцоо дансанд бүртгэж байсан гүйгээг жилийн эцэст өглөгийн дансанд шилжүүлэн тохируулах бичилт хийгээгүйгээс авлага дансыг хасах үлдэгдэлтэй тайлагнасан байна.	1	56,089.3			1	56,089.3	1	56,089.3				
3	Хувь хүнд өгөх өглөг, авлагын тооцоог үүсгэлгүй томилолтын урьдчилгаа олгоод зардал дансанд хаасан байна.	1	321,223.3			1	321,223.3	1	321,223.3				
<b>Нийт дүн</b>		<b>3</b>	<b>381,992.56</b>		-	<b>3</b>	<b>381,992.56</b>		<b>381,992.56</b>	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал	
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага				
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Дүн	тоо	Дүн
1	ЭМС-ын 2024 оны 7 дугаар сарын 03-ний өдрийн А/316 дугаар тушаалаар БНТУ-д эрүүл мэндийн байгууллагуудын удирдах ажилтныг чадавхижуулах сургалтад ЭМС болон 25 эмнэлгийн байгууллагын удирдах албан тушаалтнууд оролцож онгоцны билетэнд 62,049.0 мянган төгрөг, томилолтын зардалд 71,098.3 мянган төгрөг, нийт 133,147.0 мянган төгрөгийн гадаад томилолтын зардал гаргаж төсвийг үрэлгэн зарцуулсан	1	133,147.0			1	133,147.0							
2	Захирлын 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/199 дүгээр тушаал "Урамшуулал олгох тухай"-аар "Шилдэг алба, албан хаагчдад олгох мөнгөн урамшуулал"-д 60.0 мянган төгрөг /шилдэг алба 3, тэргүүний албан хаагч 3, шилдэг ажил 3, шилдэг удирдагч 1, тэргүүний хороо 1, спортлог албан хаагч 1, итгэлт албан хаагч 1, дэмжин туслагч 1/ шагналыг цалингийн сангаас гаргаж зориулалт бус зарцуулсан байна.	1	60,000.0			1	60,000.0							
3	Захирлын 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/199 дүгээр тушаал "Урамшуулал олгох тухай"-ын 3 дугаар хавсралтаар "Захирлын нэрэмжит шагнал олгох албан хаагчид"-д 13,000.0 мянган төгрөгийн /13 ажилтан/ шагналыг цалингийн	1	13,000.0	1	13,000.0									

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	сангаас гаргаж зориулалт бус зарцуулсан байна.												
4	Дотоод албан томилолтын хуудасгүй болон албан томилолтын хуудаст ирсэн явсан өдрийн тэмдэглэгээ хийгээгүй бүрэн баталгаажаагүй, анхан шатны бүрдэл дутуу баримтаар томилолт олгосон.	1	58,068.3			1	58,068.3						
5	Эрүүл мэндийн сайдын 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн А/236 дугаар тушаалаар баталсан "Эрүүл Монгол хүн" үндэсний хөдөлгөөний 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн хүрээнд 12 аж ахуйн нэгж, байгууллагатай 615,244.0 мянган төгрөгийн, үйл ажиллагааны зардлаас 2 төрийн бус байгууллагатай 148,153.8 мянган төгрөгийн, нийт 763,397.7 мянган төгрөгийн гэрээг байгуулж, сонгон шалгаруулалт явуулаагүй, шууд худалдан авалт хийсэн байна	1	763,397.7			1	763,397.7						
6	ТЕГ-ын шийдвэргүй захиргаа, санхүү, удирдлагын албаны ахлах мэргэжилтэнд тус төвийн захирлын тушаалаар нууцын нэмэгдлийг 20 хувиар тооцож 4 сар хүртэл 1,360.5 мянган төгрөгийн нэмэгдэл олгосон	1	1,360.5	1	1,360.53								
7	Ажил, үйлчилгээ гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан ААН, байгууллагатай жилийн эцсээр тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.	1	25,754.0			1	25,754.0						
8	Захирлын 2025 оны 10 сарын 20-ны өдрийн А/158 дугаар тушаал "Монголын эрчимт дасгалын холбоо" ТББ-тай 2025 оны 10 сарын 20-ны өдөр 122 дугаар гэрээ байгуулж БНХАУ-ын Шанхай хотод зохион байгуулагдах "Кроссфит Азийн аварга шалгаруулах" үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг	1	10,938.4			1	10,938.4						

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	үзүүлж зориулалт бус зардал гаргасан													
9	Эрүүл мэндийн төвийн захирлын 2025 оны А/103 дугаар тушаалаар 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд нягтлан бодох бүртгэлийн хөтлөлтийн чанар, үр дүнгээр сайн үнэлэгдсэн гэсэн үндэслэлээр санхүүгийн 4 албан хаагчид нийт 21,693.6 мянган төгрөгийн урамшууллыг олгосон нь ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргээ биелүүлснийг дүгнэж олгодог улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулсан байна.	1	21,693.6			1	21,693.6							
<b>Нийт дүн</b>		<b>9</b>	<b>1,087,359.5</b>	<b>2</b>	<b>14,360.5</b>	<b>7</b>	<b>1,072,999.0</b>	-	-	-	-	-	-	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 252/АОНОНО1

Улаанбаатар хот

САГ-2026/357/НА-СТА-ТУЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажил, үйлчилгээ гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан 4 аж ахуйн нэгж, байгууллагатай жилийн эцсээр 25,754,000.00 /хорин таван сая долоон зуун тавин дөрвөн мянга/ төгрөгийн авлагыг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Жилийн эцэст авлага, өглөгийн үлдэгдлийг харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал /М.Одгэрэл/, санхүү албаны дарга /С.Лхагвасүрэн/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
В.ЭРДЭНЭЦОГТ  
М.ПАГАМДУЛАМ  
Ж.БЯМБАЦОГТ



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-26 730

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-36.Docx

1526180612



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 253/А0170401-

Улаанбаатар хот

САГ-2026/357/НА-СТА-ТЦЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрүүл мэндийн төвийн захирлын 2025 оны А/103 дугаар тушаалаар 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд нягтлан бодох бүртгэлийн хөтлөлтийн чанар, үр дүнгээр сайн үнэлэгдсэн гэсэн үндэслэлээр санхүүгийн 4 албан хаагчид, нийт 21,693,600.00 *Ихорин нэг сая зургаан зуун ерэн гурван мянга зургаан зуу/* төгрөгийн урамшууллыг олгосон нь ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргээ биелүүлснийг дүгнэж олгодог улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т "Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргээ биелүүлснийг дүгнэж олгодог улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан балансын урамшуулал олгосон зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал /М.Одгэрэл/, санхүү албаны дарга /С.Лхагвасүрэн/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
В.ЭРДЭНЭЦОГТ  
М.ПАГАМДУЛАМ  
Ж.БЯМБАЦОГТ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264450

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-36.Docx

1526180604



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 254/А070401

Улаанбаатар хот

САГ-2026/357/НА-СТА-ТЦЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/199 дүгээр тушаал "Урамшуулал олгох тухай"-аар шилдэг алба, албан хаагчдад олгох мөнгөн урамшуулалд 60,000,000.00 /жаран сая/ төгрөгийн шагналыг цалингийн сангаас зориулалт бус зарцуулсан байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3-т "хуульд нийцээгүй шийдвэр гаргах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн А/99 дүгээр тушаалаар баталсан Хөдөлмөрийн дотоод журмын 8.2-д "Ажил олгогч нь ажилтанд төрийн алба хаасан хугацааны, эрдмийн зэрэг, цолны, мэргэшлийн зэргийн, ур чадвар оны нууцын ажилтны, эрх бүхий албан тушаалтны, хоол унааны нэмэгдлийг болон илүү цагаар ажиллуулсан нэмэгдэл хөлс, бусад шагнал урамшууллыг холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын шийдвэр, хөдөлмөрийн болон хамтын гэрээний холбогдох заалтыг үндэслэн, захирлын тушаалаар олгоно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Цалингийн сангаас албан хаагчдыг шагнаж төсвийн хөрөнгийг зориулалт бус зарцуулсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал /М.Одгэрэл/, санхүү албаны дарга /С.Лхагвасүрэн/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
В.ЭРДЭНЭЦОГТ  
М.ПАГАМДУЛАМ  
Ж.БЯМБАЦОГТ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрг, 1-р хороо Бигд тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-36.Docx

1526180696



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 255/А0170401

Улаанбаатар хот

САГ-2026/357/НА-СА-ТЦЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дотоод албан томилолтын хуудасгүй болон ирсэн явсан өдрийн тэмдэглэгээ хийгээгүй бүрэн баталгаажаагүй, анхан шатны бүрдэл дутуу баримтаар 58,068,275.00 /тавин найман сая жаран найман мянга хоёр зуун далан тав/ төгрөгийн томилолтын зардал олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэж, санхүүгийн тайланд тусгасан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал /М.Одгэрэл/, санхүү албаны дарга /С.Лхагвасүрэн/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
В.ЭРДЭНЭЦОГТ  
М.ПАГАМДУЛАМ  
Ж.БЯМБАЦОГТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 257/А0170401

Улаанбаатар хот

САС-2026/357/НА-СТА-ТЧЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрүүл мэндийн сайдын 2024 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн А/316 дугаар тушаалаар Бүгд Найрамдах Турк Улсад эрүүл мэндийн байгууллагуудын удирдах ажилтныг чадвхижуулах сургалтад эрүүл мэндийн сайд болон 25 эмнэлгийн байгууллагын удирдах албан тушаалтнууд оролцож онгоцны билетэнд 62,049,000.00 /жаран хоёр сая дөчин есөн мянга/ төгрөг, томилолтын зардалд 71,098,003.00 /далан нэгэн сая ерэн найман мянга гурав/ төгрөг, нийт 133,147,003.00 /нэг зуун гучин гурван сая нэг зуун дөчин долоон мянга гурав/ төгрөгийн гадаад томилолтын зардал гаргаж төсвийг үрэлгэн зарцуулсан.

Энэ Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.7-д "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсвийг үрэлгэн зарцуулсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал /М.Одгэрэл/, санхүү албаны дарга /С.Лхагвасүрэн/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
В.ЭРДЭНЭЦОГТ  
М.ПАГАМДУЛАМ  
Ж.БЯМБАЦОГТ



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-26 230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-36.Docx

1526180604



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 256/АО170401

Улаанбаатар хот

САГ-2026/357/НА-СА-ТЦЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрүүл мэндийн сайдын 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн А/236 дугаар тушаалаар баталсан "Эрүүл Монгол хүн" үндэсний хөдөлгөөний 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн хүрээнд 12 аж ахуйн нэгж, байгууллагатай 615,244,000.00 /зургаан зуун арван таван сая хоёр зуун дөчин дөрвөн мянга/ төгрөгийн, үйл ажиллагааны зардлаас 2 төрийн бус байгууллагатай 148,153,725.00 /нэг зуун дөчин найман сая нэг зуун тавин гурван мянга долоон зуун хорин тав/ төгрөгийн, нийт 763,397,725.00 /долоон зуун жаран гурван сая гурван зуун ерэн долоон мянга долоон зуун хорин тав/ төгрөгийн гэрээг байгуулж, сонгон шалгаруулалт явуулаагүй, шууд худалдан авалт хийсэн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д "Хуульд өөрөөр заагаагүй бол худалдан авах ажиллагааг зохион байгуулах, мэдээлэл солилцох, мэдээллийн ил тод байдлыг хангах ажиллагааг цахим системээр гүйцэтгэнэ" мөн хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолын хавсралтад "Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 20,000,000.00 төгрөг" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Төсөвт өртгийг хэсэгчлэн хувааж нээлтэй тендер шалгаруулалт болон харьцуулалтын аргаас зайлсхийдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал /М.Одгэрэл/, санхүү албаны дарга /С.Лхагвасүрэн/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
В.ЭРДЭНЭЦОГТ  
М.ПАГАМДУЛАМ  
Ж.БЯМБАЦОГТ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-26 230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-36.Docx

1526180642



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 45/АОНОЧОЛ-САН-2026/359/ Улаанбаатар хот  
НА-СТА-ТЦБ

### Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тагнуулын ерөнхий газрын шийдвэргүй захиргаа, санхүү, удирдлагын албаны ахлах мэргэжилтэнд тус төвийн захирлын 2020 оны Б/06 дугаар тушаалаар нууцын нэмэгдлийг 20 хувиар тооцож 4 сар хүртэл 1,360,532.00 *Инэг сая гурван зуун жаран мянга таван зуун гучин хоёр* төгрөгийн нэмэгдэл олгосон байна.

Энэ нь Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2-т "Нууц хамгаалах ажилтанд харьцаж байгаа нууцын зэрэглэл, нууцтай ажилласан хугацааг харгалзан Засгийн газраас тогтоосон журмын дагуу цалингийн нэмэгдэл олгоно.", Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолоор баталсан "Нууц хамгаалах ажилтанд цалингийн нэмэгдэл олгох журам"-ын 1.2-т "Нууц хамгаалах ажилтнаар тагнуулын байгууллагын Аюулгүй байдлын шалгалтад хамрагдаж тэнцсэн хүнийг тухайн байгууллагын удирдлагын шийдвэрээр томилно", 4.1-т "Нууц хамгаалах ажилтнаас бусад нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтанд нууц хамгаалах ажилтны цалингийн нэмэгдэл олгохыг хориглоно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-т "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж тус тус заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Тагнуулын ерөнхий газрын шийдвэргүй нууцын нэмэгдэл олгосон 1,360,532.00 *Инэг сая гурван зуун жаран мянга таван зуун гучин хоёр* төгрөгийг нөхөн төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Төлбөрийн актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал /М.Одгэрэл/, санхүү албаны дарга /С.Лхагвасүрэн/ нарт хариуцуулав.

#### АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
В.ЭРДЭНЭЦОГТ  
М.ПАГАМДУЛАМ  
Ж.БЯМБАЦОГТ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэн дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

Z:\4kn\2026\0225\_SAG-28.Docx

1526180616



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 46/АО170401-

Улаанбаатар хот

САГ-2026/357/НА-СА-ТШЗ

### Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Захирлын 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн "Урамшуулал олгох тухай" А/199 дүгээр тушаалын 3 дугаар хавсралтаар 13 албан хаагчийг 13,000,000.00 *Арван гурван сая*/ төгрөгийн захирлын нэрэмжит шагналаар, цалингийн сангаас шагнасан байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-т "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж тус тус заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Захирлын нэрэмжит шагналд цалингийн сангаас шагнасан 13,000,000.00 *Арван гурван сая*/ төгрөгийг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал М.Одгэрэлээр нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Төлбөрийн актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг санхүү албаны дарга /С.Лхагвасүрэн/ нарт хариуцуулав.

#### АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
В.ЭРДЭНЭЦОГТ  
М.ПАГАМДУЛАМ  
Ж.БЯМБАЦОГТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 258/АДИ70401  
САГ-2026/357/НА-СТЖ-ТШЗ

Улаанбаатар хот

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрүүл мэндийн төвийн захирлын 2025 оны 10 сарын 20-ны өдрийн А/158 дугаар тушаалаар "Монголын эрчимт дасгалын холбоо" төрийн бус байгууллагатай 2025 оны 10 сарын 20-ны өдөр 122 дугаар гэрээ байгуулж, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Шанхай хотод зохион байгуулагдах "Кроссфитийн Азийн аварга шалгаруулах" үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг үзүүлж 10,938,360.00/арван сая есөн зуун гучин найман мянга гурван зуун жар/ төгрөгийн зориулалт бус зардал гаргасан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 25 дугаар зүйлийн 25.10-т "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6-д "үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсвийг зориулалт бус зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал /М.Одгэрэл/, санхүү албаны дарга /С.Лхагвасүрэн/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
В.ЭРДЭНЭЦОГТ  
М.ПАГАМДУЛАМ  
Ж.БЯМБАЦОГТ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-261130

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-36.Docx

1526180692